

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт.....	14
Байхгүй.....	14
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

᠒᠔᠒᠒ - ᠐᠒ - ᠒᠕ № 3᠒

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030087

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	9,879,260.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	9,879,260.00
351	Түүхий эд материал	-	2,241,600.00
35110	Тусгай зориулалттай материал	-	300,000.00
35130	Эм боох материал	-	1,941,600.00
354	Хангамжийн материал	-	7,637,660.00
35410	Бичиг хэргийн материал	-	608,500.00
35420	Аж ахуйн материал	-	1,014,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	580,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	2,580,000.00
35450	Барилгын засварын материал	-	2,324,160.00
35470	Бусад хангамжийн материал	-	531,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	62,017,944.16	48,137,397.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,017,944.16	48,137,397.46
392	Биет хөрөнгө	62,017,944.16	48,137,397.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,419,200.00	72,419,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,449,199.76)	(35,102,533.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,738,960.11	38,738,960.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,666,583.85)	(32,706,127.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,922,214.29	24,908,214.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,946,646.63)	(20,120,316.81)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	62,017,944.16	58,016,657.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,946,796.00	1,282,665.39
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,946,796.00	1,282,665.39
413	Өглөг	3,946,796.00	1,282,665.39
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,946,796.00	139,265.39
4136	Бусад өглөг	-	1,143,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,143,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	58,071,148.16	56,733,992.07
51	Засгийн газрын хувь оролцоо	58,071,148.16	56,733,992.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,260,437.00	1,260,437.00
51101	Өмч: - төрийн	1,260,437.00	1,260,437.00
512	Хуримтлагдсан үр дүн	56,810,711.16	55,473,555.07
51210	Өмнөх үеийн үр дүн	56,810,711.16	56,810,711.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,337,156.09)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	62,017,944.16	58,016,657.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	265,320,787.03	252,428,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,857,987.03	5,477,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	46,857,987.03	5,477,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,857,987.03	5,477,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,309,000.00	5,477,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,548,987.03	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	218,462,800.00	246,950,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	205,962,800.00	236,702,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	205,962,800.00	236,702,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,500,000.00	10,248,000.00
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	3,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,248,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	226,266,007.48	253,765,556.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	226,266,007.48	253,765,556.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,584,835.04	250,096,910.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,857,762.41	202,047,155.91
210101	Үндсэн цалин	106,792,245.01	155,603,150.18
210102	Нэмэгдэл	61,716,317.40	38,704,875.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,349,200.00	7,739,130.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,043,261.15	5,250,640.22
210201	Тэтгэврийн даатгал	833,000.00	1,633,397.53
210202	Тэтгэмжийн даатгал	417,000.00	87,001.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	417,000.00	69,601.11
210205	Эрүүл мэндийн даатгал	2,376,261.15	3,460,640.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,900,000.00	6,545,040.00
210301	Гэрэл, цахилгаан	500,000.00	166,800.00
210302	Түлш, халаалт	5,000,000.00	5,666,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	712,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,942,800.00	8,554,334.00
210401	Бичиг хэрэг	1,574,800.00	1,515,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,092,300.00	5,319,834.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,037,700.00	1,150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	593,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	644,800.00	568,200.00
2105	Нормативт зардал	3,364,800.00	1,457,884.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,364,800.00	1,457,884.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	669,400.00	5,250,790.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,811,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	444,700.00	2,421,950.00
210604	Урсгал засвар	224,700.00	17,640.00
2107	Томиллолт, зочны зардал	4,450,300.00	3,989,800.00
210702	Дотоод албан томиллолт	4,450,300.00	3,989,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,309,100.00	1,134,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,820,000.00	799,720.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,500.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,047,411.48	15,866,546.70
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	10,047,411.48	15,866,546.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,681,172.44	3,668,645.26
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,681,172.44	3,668,645.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,681,172.44	2,675,103.52
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	-	993,541.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	39,054,779.55	(1,337,156.09)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	39,054,779.55	(1,337,156.09)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	229,771,800.00	252,428,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,309,000.00	5,477,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,309,000.00	5,477,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,309,000.00	5,477,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,309,000.00	5,477,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	218,462,800.00	246,950,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	205,962,800.00	236,702,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	205,962,800.00	236,702,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,500,000.00	10,248,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	3,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,248,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	212,271,800.00	250,442,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,271,800.00	250,442,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210,590,627.56	246,773,754.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,471,099.41	206,153,202.11
210101	Үндсэн цалин	101,405,582.01	114,265,426.47
210102	Нэмэгдэл	61,716,317.40	74,624,675.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,349,200.00	17,263,100.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,483,128.15	4,952,124.63
210201	Тэтгэврийн даатгал	833,000.00	1,147,489.92
210202	Тэтгэмжийн даатгал	417,000.00	87,001.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	417,000.00	69,601.11
210205	Эрүүл мэндийн даатгал	3,816,128.15	3,648,032.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,900,000.00	6,545,040.00
210301	Гэрэл, цахилгаан	500,000.00	166,800.00
210302	Түлш, халаалт	5,000,000.00	5,666,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	712,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,942,800.00	12,757,634.00
210401	Бичиг хэрэг	1,574,800.00	1,974,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,092,300.00	7,899,834.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,037,700.00	1,150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	593,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	644,800.00	1,733,000.00
2105	Нормативт зардал	3,364,800.00	3,399,484.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,364,800.00	3,399,484.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	669,400.00	7,841,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	669,400.00	4,165,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	444,700.00	2,421,950.00
210604	Урсгал засвар	224,700.00	1,254,600.00
2107	Томилолт, зочны зардал	4,450,300.00	3,989,800.00
210702	Дотоод албан томилолт	4,450,300.00	3,989,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,309,100.00	1,134,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,820,000.00	799,720.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,500.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,681,172.44	3,668,645.26
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,681,172.44	3,668,645.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,681,172.44	2,675,103.52
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	-	993,541.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,500,000.00	1,986,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,500,000.00	1,986,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,500,000.00	1,986,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,500,000.00	1,986,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,500,000.00	1,986,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(17,500,000.00)	(1,986,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,260,437.00	-	17,755,931.61	-	19,016,368.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,260,437.00	-	17,755,931.61	-	19,016,368.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	12,654,815.70	-	12,654,815.70
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,260,437.00	-	56,810,711.16	-	58,071,148.16
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,260,437.00	-	56,810,711.16	-	58,071,148.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,260,437.00	-	56,810,711.16	-	58,071,148.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,337,156.09)	-	(1,337,156.09)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,260,437.00	-	55,473,555.07	-	56,733,992.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	241,002,900.00	239,505,296.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	241,002,900.00	239,505,296.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	241,002,900.00	239,505,296.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,454,700.00	204,423,343.85
210101	Үндсэн цалин	115,319,500.00	114,265,426.47
210102	Нэмэгдэл	71,327,200.00	72,894,817.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,808,000.00	17263100.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,273,200.00	4,952,124.63
210201	Тэтгэврийн даатгал	327,700.00	1,147,489.92
210202	Тэтгэмжийн даатгал	92,100.00	87,001.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	74,500.00	69,601.11
210205	Эрүүл мэндийн даатгал	4,778,900.00	3,648,032.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,780,000.00	6,426,240.00
210301	Гэрэл, цахилгаан	500,000.00	166,800.00
210302	Түлш, халаалт	5,680,000.00	5,666,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	593440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,170,000.00	12,757,634.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,974,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,900,000.00	7,899,834.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,445,000.00	1,150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,733,000.00
2105	Нормативт зардал	3,400,000.00	3,399,484.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,400,000.00	3,399,484.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,425,000.00	2,421,950.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,425,000.00	2,421,950.00
2107	Томилот, зочны зардал	4,000,000.00	3,989,800.00
210702	Дотоод албан томилот	4,000,000.00	3,989,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	1,134,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	799,720.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	241,002,900.00	239,505,296.48
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	236,702,900.00	234,027,796.48
131001	Улсын төсвөөс санхүүжих	236,702,900.00	234,027,796.48
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,300,000.00	5,477,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,300,000.00	5,477,500.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,248,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,248,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,248,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,729,858.26
210102	Нэмэгдэл	1,729,858.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,800.00
210303	Цэвэр, бохир ус	118,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,405,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,151,200.00
210604	Урсгал засвар	1,254,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	993,541.74
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	993,541.74
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,248,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,248,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,248,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 137/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт нь шинжлэх ухааны тодорхой салбарын шинжилгээ судалгааны онол, арга барилд түшиглэн хэргийн газрын үзлэгийг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, ул мөр, эд мөрийн баримт материалуудад өндөр технологи бүхий лабораторийн техник хэрэгсэл ашиглан шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамжийн дагуу шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэн зөв дүгнэлт, магадалгаа гарган өгөх, нарийн мэргэжлийн чадварлаг зарчимч, шударга, үнэнч, мэргэшсэн алба хаагчдын үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2021 онд аймгийн Шүүхийн шинжилгээний газарт дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 226.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.0 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	00.0	00.0	-
Урьдчилгаа	00.0	00.0	-
Бараа материал	00.0	09.9	(9.9)
Үндсэн хөрөнгө	62.0	48.1	13.9
Нийт хөрөнгө	62.0	58.0	4.0
Өр төлбөр	03.9	01.3	2.7
Засгийн газрын оролцоо	58.1	56.7	1.3
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	01.3	01.3	-
Өмнөх үеийн үр дүн	56.8	56.8	-
Тайлант үеийн үр дүн	00.0	-01.3	1.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.0	00.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	62.0	58.0	4.0

Бараа материалын дансны үлдэгдэл 9.9 сая төгрөгөөр өсөж, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13.9 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны өр 1.3 сая төгрөг болж 2.7 сая төгрөгөөр буурсан нь татварын өрийг бүрэн барагдуулснаар буурч, бараа материал худалдан авсны өглөг нэмэгджээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1.3 сая төгрөг байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 11.9 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 28.5 сая төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн нь цалин хөлсний зардалтай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 247.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн саналаар төсвийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 247.0 сая төгрөг баталсныг 244.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 4.3 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 236.7 сая төгрөг, үндсэн ажиллагааны орлого 5.5 сая төгрөг нийт 242.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 239.5 сая төгрөг зарцуулж, 2.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7.2 сая төгрөг нийт 10.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 9.2 сая төгрөгийг зарцуулж, 1.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцлох асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Жилийн эцэст хэмнэгдсэн зардлаас шаардлагатай зардалд зохицуулалт хийлгэхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан эдийн засгийн ангиллыг баримтлан шаардлагатай зардлыг зөв хуваарилалт хийгээгүйгээс төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй тус тушаалыг зөрчиж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий санхүүжилтийн 235.9 сая төгрөгийн 12 гүйлгээ гарснаас 128.4 сая төгрөгийн 7 гүйлгээ, эхний хагас жилийн санхүүгийн тайланг шилэн дансанд мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн боловч тайланд онд зөрчил давтагдан гарч зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын тайлан гаргалт, тооллого, тооцоо бодолт, үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэлийг авч үзэх болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 130.9. сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 0.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 130.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Цалингийн зардлыг тооцоолсон цалингаас 0.5 сая төгрөгөөр илүү бүртгэснийг аудитын хугацаанд залруулав.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Өмнөх оны аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 128.4 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин хөдөлмөр хамгааллын хэрэгслээс жижиг эд хогшил худалдан авч төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний алба	3	130.9	1	0.5			2	130.4		
Дүн		3	130.9	1	0.5			2	130.4		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 19/АДЗ70448
ХЭТ/2022/07/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд 128,421.5 мянган төгрөгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т "...хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг тогтмол мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих мэдээллийг тогтсон хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн шинжилгээний албаны дарга, цагдаагийн дэд хурандаа Ш.Цолмон, нягтлан бодогч Х.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 20/А 2370448
ХДА-2022/07/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин хөдөлмөр хамгааллын хэрэгслээс 1,974.9 мянган төгрөгийн жижиг эд хогшил бэлтгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг мөрдөн ажилладаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн шинжилгээний албаны дарга, цагдаагийн дэд хурандаа Ш.Цолмон, нягтлан бодогч Х.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

